

“Монгео” ХК –ийн 2016 оны үйл
ажиллагааны тайлан, цаашдын зорилт

“Мон-Гео” ХК нь тайлант хугацаанд компанийн тухай хууль, компанийн дүрэм, батлагдсан дотоод журам, СЗХ-оос баталсан журам, ХНХурлын болон компанийн ТУЗ-ийн хурлын шийдвэрүүдийг биелүүлэн ажиллах чиглэл баримтлан үйл ажиллагаагаа явуулж дуусгалаа.

Манай компани “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн төв” ХХК-тай үнэт цаасны хадгаламжийн болон үнэт цаастай холбогдолтой төлбөр тооцоо гүйцэтгэх гэрээг хугацаанд нь байгуулан зохих төлбөрийг барагдуулан хамтран ажиллаж байна.

Мөн Санхүүгийн Зохицуулах Хороо, Хөрөнгийн Биржтэй хамтран ажиллалаа.

Өнөөгийн байдлаар компанийн өөрийн эзэмшлийн 21,3-272 М² талбай бүхий өрөөнүүдийг үйлдвэрлэл, конторын зориулалтаар аж ахуйн нэгж болон хувь хүнд түрээслэн түрээсийн үйл ажиллагаа явуулж байгаа болно.

Компани одоогоор 8 хүний орон тоогоор ажиллаж байна. Үүнд үндсэн ажилтан 5, гэрээт ажиллагсад 3 хүн байдаг. Сар бүр ажлаа төлөвлөн биелэлтийг хянан ажилладаг.

Сар бүр байгууллагын санхүүд төвлөрдөг түрээсийн орлогыг аль болох боломжоор нь хуваарилан зарцуулдаг юм.

Тайлант хугацаанд 81,444,281 төгрөгийн орлого төвлөрснөөс зээл, зээлийн хүү бүх төрлийн татварыг төлөн байгууллагын ажиллагсдын цалин болон бусад үйл ажиллагааны зардлуудыг төлөх ажлыг гүйцэтгэлээ.

2016 онд Санхүү, татварын тайланг цаг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэн жилийн эцэст “Б ЭНД С АУДИТ” ХХК Аудитын байгууллагаар хянуулсан байна. Мон-гео ХК 2016 оны жилийн эцсээр дулааны төлбөрт 1080569 төгрөг, татвар, нийгмийн даатгалын байгууллагад 3150771 төгрөгийн өглөгтэй байна.

Өнгөрсөн оны хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаас гаргасан шийдвэрүүдийг зохих түвшинд нь биелүүлэн ажиллалаа.

Байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэх, орлого нэмэгдүүлэх зорилгоор 5,000,000 /таван сая төгрөг/-өөр хүлэмж, бусад туслах материалыг худалдан авч өргөст хэмх, улаан лооль тарьж ургууллаа. 150 үрсэлгээ тарьснаас 100 ш нь өргөст

хэмх, 50 ш улаан лооль байв. Тооцоо ёсоор 2000 гаруй кг өргөст хэмх, 700 гаруй кг улаан лооль хураан авах байсан боловч 90 кг улаан лооль 800 гаруй кг өргөст хэмх хураан авсан бөгөөд нийт 650000 /зургаан зуун тавин мянган төгрөгийн орлого олжээ.

Ургац алдсан шалтгаан нь:

Улс орны бүх салбарын байгууллага, хувь хүмүүсийн эдийн засгийн чадавхи муудсан, мөнгөгүй болсон, улс орныг бүхэлд нь хамарсан эдийн засгийн хямралаас үүдэн өнгөрсөн хурлаар шийдвэрлэсэн компанийн бизнес төлөвлөгөө төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх боломжийн нөхцөл бүрдээгүй болно.

Өнгөрсөн онд “Газар партнерс” ББСБ-с зээлсэн зээлийн үлдэгдэл 17,590,000 /Арван долоон сая таван зуун ерэн мянган төгрөг/-ийг төлж барагдууллаа.

Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар улсын чанартай зохион байгуулагдах ажилд бид биечлэн оролцож чадсангүй. Энэ нь эдийн засгийн хямрал, мөнгөний хомсдлоос болж байна гэж үзэж байна.

“Мон-Гео” ХК-ийн 2 давхар 2301 М² барилгын дээвэр бороо цасны усыг тогтоож чадахгүй болж маш их ус нэвчин гоожиж өрөө тасалгааны хана болон бусад зүйлст хүчтэй нөлөөлсөн.

Компани оршин тогтнохын тулд дээврийн их засвар хийхээс өөр ямар ч арга байхгүй болсон.

Барилга 1996 онд ашиглалтад орсон. Үүнээс хойш нэг ч удаа их засвар хийгээгүй бөгөөд 2008, 2011 онуудад урсгал засвар хийсэн түүхтэй.

Иймд компани 30,000,000 төгрөгийн зээл авч “ТИ БИ ЭН ЭМ” ХХК-р ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулан 38400000 /гучин найман сая дөрвөн зуун мянган/ төгрөгийн төсөвтэй дээврийн капитал засварыг хугацаа алдалгүй чанартай гүйцэтгүүлж, ус гоожих дулаан алдах зэрэг сөрөг үр дагавруудыг 100 хувь таслан зогсоож чадсан болно. Жилийн эцсээр НДШ, бусад татварын өртэй гарсан байна.

Тус компанийн 21,3-54 м.кв талбайтай оффисийн зориулалтаар ашиглах засвар хийсэн 4 өрөө, мөн үйлдвэрлэл болон бусад чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж болохуйц 64-72 м.кв 3 өрөө сул байна.

Эдгээр өрөөнүүдийг түрээслүүлж чадах юм бол сарын зардлаа нөхөөд байх боломжтой болох юм.

Мөн тайлант хугацааны эцсээр иргэн М.Ариунболд гэгч гарал үүсэл нь тодорхойгүй 9000 /есөн мянга/ ширхэг хувьцааг зарах санал тавьсан.

Гэвч бид санхүүгийн боломжгүй байгаагаас улбаалан худалдаж авах боломжгүй гэсэн хариуг өгсөн болно.

Цаашдын зорилтын хувьд:

1.Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэх, үнэт цаасны зах зээлийг судлах,/ хувьцаа худалдах, худалдан авах, шинээр хувьцаа гаргах гэх мэт /

2. Эдийн засгийн чадамжтай болох талаар дорвитой үйл ажиллагаа хийх, төлөвлөх, тооцох хэрэгтэй.

3. Гадаад харилцааг судлах, боломжийг болон таатай нөхцлийг эрэлхийх,

4. Хөрөнгө оруулалт, бусад нөхцөл байдлыг судлан хөөцөлдөж боломжоороо компанийн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэх гарц олох ,

5, Компани үндсэн үйл ажилагааныхаа чиглэлээр ажиллах бүрэн боломжтой тул энэ талаар судлах арга хэмжээ авах зэрэг ажлуудыг цаашид хийх шаардлагатай байна.

Хурлаас гарах санал, шийдвэрүүдийг хүндэтгэн хүлээн авч компанийн үйл ажиллагааг чиглүүлэн гүйцэтгэж ажиллах болно.

Анхаарал тавьсанд баярлалаа

“Монгео” ХК –ийн захиргаа

2017.3.17

